ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ургамал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ЗАА-2024/136/НА-СТА-ТШЗ


Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

“Хаан соёмбо аудит” ХХК-ийн гэрээт аудитор Ж.Буянтогтох

Утас: 9904 2814

Цахим хаяг: buyanaa99042824@gmail.com

Цахим хуудас: www.audit.mn

Улиастай сум

2025 он


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**


1. Хараат бус аудиторын дүгнэлт 3

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 4

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 4

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан 4

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 5

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 7

3. Санхүүгийн тайлангийн тодруулга....8

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 8

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 10

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 10

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт 11

4. Аудитын тайлан....13

4.1 Ерөнхий зүйл ....13

4.2 Материаллаг байдал ....14

4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт....14

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....14

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....15

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....16

5. Аудитын илрүүлэлт ....16

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.02.11 № 58

танай ____________-ны № ____________-т

УРГАМАЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ О.МӨНГӨНТУУЛ-Д

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ургамал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ургамал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Ургамал сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2024 онд 1,188,156.9 мянган төгрөгийн санхүүжилттэй ажиллаж, 279,005.9 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй, утасгүй интернетийн төхөөрөмжийн 81,765.5 мянган төгрөгийн өглөгтэй ажилласан байна.

Аудитын гол асуудал

Ургамал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн 156 нэр төрлийн 202,409.9 мянган төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгийг дахин үнэлж, ашиглах хугацааг сунгаагүй, дотуур байрны хүүхдийн хоолыг өдөрт 7502 хүүхдээр тооцож 29,427.7 мянган төгрөгийн зарлагыг нярвын бараа материалын тайланд тусгасан боловч балансТ 34,297.6 мянган төгрөгөөр зарлага гаргаж, байна.

Бусад асуудлын хэсэг

Ургамал сумын Ерөнхий боловсролын сургууль нь сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр дотуур байрны хүүхэд хөгжлийн танхимыг 5.0 сая төгрөгөөр тохижуулсан байна.

өрөнхий газрын хөрөнгө оруулалтаар ирсэн 39 инчийн зурагт, гитар, сэтгэхүй хөгжүүлэх 5 төрлийн 20 ширхэг тоглоом, хивс, гар утас хураах хайрцаг, 8 ширхэг бөхийн өмсгөл зэрэг хөрөнгийг данс бүртгэлд тусгажээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшний болович үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31* *Iтөгрөгөөр/*

| Данс | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| I | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **109,789,704.50** | **346,353,242.16** |
| 31 | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **42,254,576.66** | **279,005,965.39** |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 42,254,576.66 | 279,005,965.39 |
| 3121 | Төгрөг | 42,254,576.66 | 279,005,965.39 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 42,254,576.66 | 279,005,965.39 |
| 33 | **АВЛАГА** | **571,413.29** | **465,216.93** |
| 331 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 571,413.29 | 465,216.93 |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | **66,963,714.55** | **66,882,059.84** |
| 351 | Түүхий эд материал | 13,148,864.15 | 13,887,109.44 |
| 3511 | Тусгай зориулалттай материал | 12,901,864.15 | 13,887,109.44 |
| 3513 | Эм боох материал | 247,000.00 | |
| 353 | Бэлэн бүтээгдэхүүн | 5,187,500.00 | 3,537,000.00 |
| 354 | Хангамжийн материал | 48,627,350.40 | 49,457,950.40 |
| 3541 | Бичиг хэргийн материал | 648,450.00 | 1,175,100.00 |
| 3542 | Аж ахуйн материал | 32,435,915.98 | 34,386,015.98 |
| 3543 | Сэлбэг хэрэгсэл | 880,000.00 | 880,000.00 |
| 3544 | Түлш, шатах тослох материал | 232,000.00 | 232,000.00 |
| 3545 | Барилгын засварын материал | 895,200.00 | 1,294,550.00 |
| 3546 | Хүнсний материал | 2,117,000.00 | 71,500.00 |
| 3547 | Бусад хангамжийн материал | 11,418,784.42 | 11,418,784.42 |
| II | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **467,928,637.98** | **562,398,573.12** |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **467,928,637.98** | **562,398,573.12** |
| 392 | Биет хөрөнгө | 408,886,762.98 | 503,666,073.12 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 442,997,556.00 | 442,997,556.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -174,498,745.44 | -192,343,445.13 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 16,335,000.00 | 16,335,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -15,084,999.78 | -15,710,000.01 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 186,815,860.01 | 320,909,150.01 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -108,907,161.35 | -129,096,716.47 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 92,395,717.23 | 94,895,717.23 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -56,219,308.47 | -61,079,990.76 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 9,441,200.00 | 9,441,200.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -6,175,394.88 | -6,719,437.41 |
| 39217 | Ном | 21,787,039.66 | 24,037,039.66 |
| 393 | Биет бус хөрөнгө | 59,041,875.00 | 58,732,500.00 |
| 39301 | **Програм хангамж** | **2,400,000.00** | **2,400,000.00** |
| 39302 | **Хуримтлагдсан элэгдэл** | **-1,678,125.00** | **-1,987,500.00** |
| 39303 | **Бусад биет бус хөрөнгө** | **58,320,000.00** | **58,320,000.00** |
| III | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **577,718,342.48** | **908,751,815.28** |
| IV | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | | **81,765,548.00** |
| 41 | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | | **81,765,548.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 413 | Өглөг | | 81,765,548.00 |
| 4136 | Бусад өглөг | | 81,765,548.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | | 81,765,548.00 |
| V | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **577,718,342.48** | **826,986,267.28** |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | **577,718,342.48** | **826,986,267.28** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 436,727,137.20 | 436,727,137.20 |
| 51101 | Өмч: - төрийн | 436,727,137.20 | 436,727,137.20 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | -189,898,135.87 | 59,369,788.93 |
| 5121 | Өмнөх үеийн үр дүн | -189,898,135.87 | -189,898,135.87 |
| 5122 | Тайлант үеийн үр дүн | | 249,267,924.80 |
| 513 | **Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү** | **330,889,341.15** | **330,889,341.15** |
| VI | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **577,718,342.48** | **908,751,815.28** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31* *\/төгрөгөөр/*

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **776,596,214.92** | **1,358,463,058.50** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **33,300,714.92** | **17,663,258.50** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | **33,300,714.92** | **17,663,258.50** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,159,500.00 | 1,260,500.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 1,260,500.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,159,500.00 | |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 27,332,307.50 | 15,310,690.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 4,808,907.42 | 1,092,068.50 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 743,295,500.00 | 1,340,799,800.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 609,266,500.00 | 1,186,896,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 609,266,500.00 | 1,186,896,400.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 134,029,000.00 | 153,903,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 134,029,000.00 | 153,903,400.00 |
| II | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **852,683,544.89** | **1,109,195,133.70** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **852,683,544.89** | **1,109,195,133.70** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **827,723,770.30** | **1,083,010,490.97** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 510,836,494.27 | 725,034,387.54 |
| 210101 | Үндсэн цалин | 368,598,327.27 | 457,330,170.68 |
| 210102 | Нэмэгдэл | 121,262,344.00 | 237,938,410.86 |
| 210104 | Урамшуулал | 20,975,823.00 | 29,765,806.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 64,631,114.62 | 91,644,707.80 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 44,194,140.92 | 62,682,632.41 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,571,125.86 | 7,201,276.77 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,636,281.09 | 3,600,638.65 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,011,321.31 | 3,600,638.65 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,218,245.44 | 14,559,521.32 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 128,333,475.41 | 148,482,457.27 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,556,557.45 | 9,163,188.10 |
| 210302 | Түлш, халаалт | 120,776,917.96 | 139,319,269.17 |

| | | | |
|---|---|---|---|
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 9,076,262.20 | 18,012,243.21 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,827,995.00 | 4,741,520.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,410,000.00 | 5,436,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,838,267.20 | 7,833,923.21 |
| 2105 | Нормативд зардал | 39,719,490.00 | 34,544,600.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 345,150.00 | 247,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 39,374,340.00 | 34,297,600.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,736,000.00 | 5,260,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,736,000.00 | 5,260,100.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,809,000.00 | 5,112,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,809,000.00 | 5,112,200.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 6,251,500.00 | 4,286,176.29 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,835,700.00 | 1,260,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,440,000.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,975,800.00 | 3,025,976.29 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 62,330,433.80 | 50,633,618.86 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,622,848.00 | 6,212,139.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,418,800.00 | 48,125.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 44,288,785.80 | 44,373,354.86 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **24,959,774.59** | **26,184,642.73** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 24,143,650.00 | 24,594,800.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 24,143,650.00 | 24,594,800.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 816,124.59 | |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 816,124.59 | |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | | 1,589,842.73 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 1,589,842.73 |
| III | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН** | **-76,087,329.97** | **249,267,924.80** |
| V | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-76,087,329.97** | **249,267,924.80** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31* *\/төгрөгөөр/*

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **744,455,000.00** | **1,342,060,300.00** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,159,500.00** | **1,260,500.00** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,159,500.00 | 1,260,500.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,159,500.00 | 1,260,500.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 1,260,500.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,159,500.00 | |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 743,295,500.00 | 1,340,799,800.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 609,266,500.00 | 1,186,896,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 609,266,500.00 | 1,186,896,400.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 134,029,000.00 | 153,903,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 134,029,000.00 | 153,903,400.00 |
| II | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **800,181,458.89** | **1,063,541,859.27** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **800,181,458.89** | **1,063,541,859.27** |

| | | | |
|---|---|---|---|
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **769,159,084.30** | **1,039,007,716.54** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 511,020,236.27 | 723,640,799.11 |
| 210101 | Үндсэн цалин | 362,811,522.27 | 443,197,259.21 |
| 210102 | Нэмэгдэл | 125,148,230.00 | 252,172,433.90 |
| 210104 | Урамшуулал | 23,060,484.00 | 28,271,106.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 64,357,372.62 | 92,932,099.87 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 43,848,870.23 | 62,896,238.65 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,127,544.14 | 7,508,115.30 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,101,715.09 | 3,756,357.66 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,024,255.41 | 3,754,257.66 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,254,987.75 | 15,017,130.60 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 129,213,475.41 | 148,482,457.27 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,455,021.75 | 9,163,188.10 |
| 210302 | Түлш, халаалт | 119,877,400.00 | 139,319,162.41 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 881,053.66 | 106.76 |
| 2105 | Нормативт зардал | 40,254,250.00 | 32,252,100.00 |
| 210502 | Хоол, хүнс | 40,254,250.00 | 32,252,100.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,999,400.00 | 3,831,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,999,400.00 | 3,831,100.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,617,300.00 | 7,400,860.29 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,041,500.00 | 1,260,200.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,575,800.00 | 6,140,660.29 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,697,050.00 | 30,468,300.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,760,400.00 | 24,997,100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,936,650.00 | 5,471,200.00 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **31,022,374.59** | **24,534,142.73** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 30,206,250.00 | 22,944,300.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 30,206,250.00 | 22,944,300.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 816,124.59 | |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 816,124.59 | |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | | 1,589,842.73 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 1,589,842.73 |
| III | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-55,726,458.89** | **278,518,440.73** |
| V | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН** | **12,650,000.00** | **41,767,052.00** |
| | Дотоод эх үүсвэрээр | 12,650,000.00 | 41,767,052.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 12,650,000.00 | 41,767,052.00 |
| VI | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-12,650,000.00** | **-41,767,052.00** |
| VIII | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **-68,376,458.89** | **236,751,388.73** |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 42,254,576.66 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 279,005,965.39 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31* */төгрөгөөр/*

| Д/Д | Үзүүлэлт | Засгийн газрын сан | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | ЗГ-н хувь оролцооны дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 436,727,137.20 | 330,889,341.15 | -189,898,135.87 | 577,718,342.48 |
| 2 | Тайлант үеийн үр дүн | | | 249,267,924.80 | 249,267,924.80 |
| 3 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 436,727,137.20 | 330,889,341.15 | -189,898,135.87 | 577,718,342.48 |
| 4 | Тайлант үеийн үр дүн | | | 249,267,924.80 | 249,267,924.80 |
| 5 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 436,727,137.20 | 330,889,341.15 | 59,369,788.93 | 826,986,267.28 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31* */төгрөгөөр/*

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн |
|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,383,695,300.00** | **951,405,511.27** | **432,289,788.73** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,383,695,300.00** | **909,638,459.27** | **474,056,840.73** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,355,703,900.00** | **886,694,159.27** | **469,009,740.73** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **958,505,000.00** | **723,640,799.11** | **234,864,200.89** |
| 210101 | Үндсэн цалин | 716,214,000.00 | 443,197,259.21 | 273,016,740.79 |
| 210102 | Нэмэгдэл | 225,404,500.00 | 252,172,433.90 | -26,767,933.90 |
| 210104 | Урамшуулал | 16,886,500.00 | 28,271,106.00 | -11,384,606.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **119,813,100.00** | **92,932,099.87** | **26,881,000.13** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 81,472,900.00 | 62,896,238.65 | 18,576,661.35 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,585,000.00 | 7,508,115.30 | 2,076,884.70 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,792,500.00 | 3,756,357.66 | 1,036,142.34 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,792,500.00 | 3,754,257.66 | 1,038,242.34 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 19,170,200.00 | 15,017,130.60 | 4,153,069.40 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **149,903,400.00** | **149,903,400.00** | |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,114,400.00 | 9,114,400.00 | |
| 210302 | Түлш, халаалт | 139,751,800.00 | 139,751,800.00 | |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,037,200.00 | 1,037,200.00 | |
| 2105 | Нормативт зардал | 37,457,600.00 | 32,252,100.00 | 5,205,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 37,457,600.00 | 32,252,100.00 | 5,205,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **4,000,000.00** | | **4,000,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 4,000,000.00 | | 4,000,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 16,101,600.00 | 7,400,860.29 | 8,700,739.71 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,260,500.00 | 1,260,200.00 | 300 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 14,841,100.00 | 6,140,660.29 | 8,700,439.71 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **69,923,200.00** | **30,468,300.00** | **39,454,900.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 64,452,000.00 | 24,997,100.00 | 39,454,900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,471,200.00 | 5,471,200.00 | |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **27,991,400.00** | **22,944,300.00** | **5,047,100.00** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 27,991,400.00 | 22,944,300.00 | 5,047,100.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 27,991,400.00 | 22,944,300.00 | 5,047,100.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | **41,767,052.00** | **-41,767,052.00** |
| | Дотоод эх үүсвэрээр | | 41,767,052.00 | -41,767,052.00 |
| **1** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,383,695,300.00** | **1,188,156,900.00** | **195,538,400.00** |
| **131** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,186,896,400.00** | **1,186,896,400.00** | |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,186,896,400.00 | 1,186,896,400.00 | |
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 153,903,400.00 | | 153,903,400.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 153,903,400.00 | | 153,903,400.00 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 42,895,500.00 | 1,260,500.00 | 41,635,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 1,260,500.00 | -1,260,500.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 41,635,000.00 | | 41,635,000.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 42,254,576.66 | 42,254,576.66 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 279,005,965.39 | 279,005,965.39 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31* *\/төгрөгөөр/*

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **153,903,400.00** | **153,903,400.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **153,903,400.00** | **153,903,400.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **152,313,557.27** | **152,313,557.27** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **148,482,457.27** | **148,482,457.27** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,163,188.10 | 9,163,188.10 |
| 210302 | Түлш, халаалт | 139,319,162.41 | 139,319,162.41 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 106.76 | 106.76 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **3,831,100.00** | **3,831,100.00** |
| 210604 | Урсгал засвар | 3,831,100.00 | 3,831,100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,589,842.73** | **1,589,842.73** |
| | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | 1,589,842.73 | 1,589,842.73 |
| **1** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **153,903,400.00** | **153,903,400.00** |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

***Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэл:*** Хүүхэд бүрийн сурч хөгжих, эрүүл зөв амьдрах дадал, үйлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгаж, суралцах тэгш боломжийг бүрдүүлэн, хичээл сургалтын үйл ажиллагаанд бүх талын хамтын оролцоог дэмжих, багш ажилтны ёс зүй, өөрийн удирдлагатай суралцахуй, багшлахуйг эрхэмлэн хөгжүүлэх замаар сургалт, үйл ажиллагааны чанарт ахиц гаргахаар зорилго тавин ажиллаж байна.

***Ерөнхий боловсролын сургуулийн зорилго:*** Хүүхдийн сурах үйлийг дэмжиж сурлагын хоцрогдлыг багасган, тэдний хөгжил төлөвшил сурлагын чанарт ахиц гарган хамтын ажиллагааг өргөжүүлэхэд оршино.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд мөрддөг хууль:

1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
2. Төрийн албаны тухай хууль
3. Боловсролын тухай хууль
4. Төсвийн тухай хууль
5. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
6. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
7. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
8. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
9. Хөдөлмөрийн тухай хууль
10. Бага дунд боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Дотоод хяналтын багийг байгуулж, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Мөн санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд ЕБС-ийн захирал, санхүүгийн албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ургамал сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ургамал сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 331,033.5 мянган төгрөгөөр буюу 57.3 хувиар өссөн байна.

***Хүснэгт 1.*** *Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 571,4 | 465,2 | 106,2 |
| Бараа материал | 66,963.7 | 66,882.1 | 81,6 |
| Үндсэн хөрөнгө | 467,928.6 | 562,398.6 | 94,470.0 |
| **Нийт хөрөнгө** | **577,718.3** | **908,751.8** | **331,033.5** |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 577,718.3 | 826,986.3 | 249,268.0 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **577,718.3** | **908,751.8** | **331,033.5** |

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

**Тайланд онд:**

Авлагын эхний үлдэгдэл 571.4 мянган төгрөг, тайлант онд 106.2 мянган төгрөгийн авлага барагдаж, эцсийн үлдэгдэл 465.2 мянган төгрөг болсон байна.
Бараа материалын эхний үлдэгдэл 66,963.7 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 81,238.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, Хандиваар 1,092.1 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 82,411.7 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, эцсийн үлдэгдэл 66,882.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 81,6 мянган төгрөгөөр өссөн байна.
Үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр 123,532.6 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хөрөнгө оруулалтаар 15,310.7 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, жилийн эцэст 562,398.6 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 44,373.3 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 249,268.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,186,896.4 мянган төгрөг, нийт зарлагыг 1,186,896.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг тодотголоор нэмж баталсан байна.

**3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн зардлын гүйцэтгэл 1 хөтөлбөр, 13 арга хэмжээнд нийт 907,890.5 мянган төгрөг буюу 76.5 хувьтай зарцуулсан байна. Цалин хөлсний зардал 234,864.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 39.454.9 мянган төгрөг, хоолны зардал 5,205.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/мянган төгрөгөөр/*

| Хөтөлбөр арга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | | | | |
| 71802 | Ерөнхий боловсрол | | | |
| 80226 | Байр ашиглалтын үйлчилгээ | 1,626.40 | 1,593.70 | 32.7 |
| 80233 | Хүүхэд хамгаалал | 1,572.40 | 1,572.40 | 0 |
| 80312 | Сургалт семинар | 1,098.00 | 1,071.90 | 26.1 |
| 81605 | Эрүүл мэндийг дэмжих | 1,367.80 | 1,367.80 | 0 |
| 81801 | Үдийн цай хөтөлбөр | 27,991.40 | 22,944.30 | 5,047.10 |
| 81806 | Дотуур байрны үйлчилгээ | 177,985.80 | 140,606.10 | 37,379.70 |
| 81816 | Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 43,198.40 | 43,182.30 | 16.1 |
| 81823 | Боловсролын байгууллагын багш ажилтны мэргэжил дээшлүүлэх | 4,206.30 | 3,965.00 | 241.3 |
| 81834 | Боловсролын стандарт | 907,813.40 | 674,405.10 | 233,408.30 |
| 81835 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 16,181.00 | 14,597.30 | 1,583.70 |
| 81848 | Сурах бичгийн түрээс | 1,260.50 | 1,260.50 | |
| 81875 | Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх | 2,522.00 | 1,251.90 | 1,270.10 |
| 83603 | Нэмэлт-дээд шатны төсвөөс хуваарилсан | 73 | 73 | |
| **НИЙТ** | | **1,186,896.40** | **907,890.50** | **279,005.90** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

| Хөтөлбөр арга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 71802 | Ерөнхий боловсрол | | | | |
| 80109 | ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал | 153,903.4 | 152,313.5 | 1,589.9 | 98.9 |
| **НИЙТ** | | **153,903.4** | **152,313.5** | **1,589.9** | **98.9** |

Орон нутгийн төсвийн санхүүжилтээр 153,903.4 мянган төгрөгийн тогтмол зардал төвлөрүүлж, батлагдсан төсвийн дагуу 152,313.5 мянган төгрөгийг зарцуулж, 1,589.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

*/мянган төгрөгөөр/*

| № | Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга | Бараа ажил үйлчилгээний нэр | Төлөвлөлт | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|
| 1 | Шууд гэрээ байгуулах | Үдийн цай | 27,991.4 | 22,944.3 |
| 2 | Шууд гэрээ байгуулах | Түлш халаалтын зардал | 139,751.8 | 139,751.8 |
| 3 | Шууд гэрээ байгуулах | Гэрэл цахилгааны зардал | 9,114.4 | 9,114.4 |
| 4 | Шууд гэрээ байгуулах | Цэвэр бохир усны зардал | 1,037.2 | 1,037.2 |
| 5 | Шууд гэрээ байгуулах | Урсгал засварын зардал | 4,000.0 | 0 |
| 6 | Шууд гэрээ байгуулах | Бусдаар гүйцэтгүүлсний төлбөр хураамж | 16,101.6 | 7,400.8 |
| 7 | Шууд гэрээ байгуулах | Бараа үйлчилгээний бусад зардал | 69,923.2 | 30,468.3 |
| 8 | Шууд гэрээ байгуулах | Хоол | 37,457.6 | 32,252.1 |
| **ДҮН** | | | **305,377.2** | **242,968.9** |

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Ургамал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг "Хаан соёмбо аудит" ХХК-ийн гэрээт аудитор Ж.Буянтогтох гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн анхан шатанд хянаж, чанарын хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсвэд, аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Ургамал сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 10 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 852,683.5 мянган төгрөгийн орлогын дүнгээс 1 хувиар буюу 8,526.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 6821.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 1,358,463.0 мянган төгрөгийн орлогын дүнгээс 1 хувиар буюу 13,846.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 10,867.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 5 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Ургамал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар акт ,албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | | | | | |
| Зөвлөмж | | | | | |
| **Нийт дүн** | | | | | |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар хүүхдийн хоол, үдийн цайны зарцуулалтад хяналт тавих;

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4,869.8 мянган төгрөгийн , зөрчил илэрч төлбөрийн акт тогтоож, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, үлдэх өртөггүй хөрөнгөнд зөвлөмж өгөв.

***Залруулсан алдаа:*** *Залруулсан алдаа байхгүй*

**5.1 Төлбөрийн акт**

Дотуур байрны хүүхдийн хоолны материалыг нярвын бараа материалын тайлангаас 4,869,850 төгрөгөөр илүү зарлагадсан зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

**5.2 Албан шаардлага өгөгдөөгүй**

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

***Илрүүлэлт***: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 156 төрлийн 202,409.9 мянган төгрөгийн хөрөнгө элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэгдэл өртөггүй хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

***Өгсөн зөвлөмж:*** Дахин үнэлгээ хийх шалгуур хангасан хөрөнгөнд үнэлгээ хийж бүртгэлд тусгах, цаашид ашиглах боломжгүй хөрөнгүүдийг холбогдох газрын зөвшөөрлийн дагуу данснаас хасах арга хэмжээ авч, үндсэн хөрөнгийн бүртгэлийг цэгцлэх;

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Нийт илрүүлсэн 4,869.8 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Дотуур байрны хүүхдийн хоолны материалыг нярвын бараа материалын тайлангаас 4,869,850 төгрөгөөр илүү зарлагадсан | 1 | 4,869.8 | 1 | 4,869.8 | | | | | | | | |
| Үндсэн хөрөнгийн дансанд 156 төрлийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэгдэл өртөггүй хөрөнгө бүртгэлтэй байна. | 1 | | | | | | 1 | | | | | |
| **Дүн** | **2** | **4869.8** | **1** | **4869.8** | | | **1** | | | | | |

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

**ХЯНАСАН:**

АХЛАХ АУДИТОР Ц.ОЮУНСУВД

АУДИТЫН МЕНЕЖЕР: Х.БОЛДБААТАР

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

Огноо: 2025-02-24

**БОЛОВСРУУЛСАН:**

“ХААН СОЁМБО АУДИТ” ХХК-ИЙН

ГЭРЭЭТ АУДИТОР Ж.БУЯНТОГТОХ

Огноо: 2025-02-24